ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

“ГАН ХИЙЦ” ХК-НИЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

2025 оны 12 сарын 31-ний өдрийн санхүүгийн дуусвар тайлан

2026 он

Ган хийц ХК
2025 оны санхүүгийн тайлангийн
бодит байдлын тухай мэдэгдэл

2025 оны 12 - р сарын 31-ны өдөр

Захирал М.Даваасүрэн, нягтлан бодогч Х.Ариунсанаа бид манай аж ахуйн нэгжийн 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг " Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийн 9.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд :

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан,
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн,
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан,
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй,
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан,
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

2880988 ÷ 1115204692
ГАН ХИЙЦ ХК
УЛААНБААТАР ХОТ

ЗАХИРАЛ
..... М.ДАВААСҮРЭН

НЯГТЛАН БОДОГЧ
..... Х.АРИУНСАНАА

DUM AUDIT
БҮРТГЭЛ, ХЯНАЛТ, ЗӨВЛӨГӨӨ

ДУНДМАНХАЙДАЙ
АУДИТ ХХК

15171 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бакула Ринбүүчийн гудамж, Оршил-2 төв, 5 давхар,
Утас: 9908 5151, 9199 1462, Факс: (976-11) 32 52 62,
И-мэйл: byambaahunnu@yahoo.com, Вэб: www.dumaudit.mn

2026 05. 11 № 58

танай _____-ны №_____-т

"ГАН ХИЙЦ" ХК-ИЙН ТУЗ-ЫН
ДАРГА М.ДАВААСҮРЭН БОЛОН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасны дагуу "Ган хийц" ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмч өөрчлөлтийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тус компани нь доорх гол асуудалд анхаарах шаардлагатай байна. Үүнд:

1. Компани нь жижиг мөнгөн сан ашиглан мөнгөн гүйлгээг бэлнээр хийж, хадгалж буй нь эрсдэлийг дагуулж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн доорх заалтуудыг зөрчсөн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;
2. Санхүүгийн тайланд тусгасан татварын өглөг 2025 оны 12 дугаар сарын 31-өдрийн байдлаар 1,223,015,160,305.19 буюу өмнөх оны үлдэгдлээс 114,145,184.97 төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 160,209,248.83 буюу өмнөх оны үлдэгдлээс 110,648,018.82 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг төсөвт төлөх үүргээ биелээгүй байна.

3. Компани нь 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангаар нийт хөрөнгөөс өр төлбөрийн дүнг хасвал өөрийн хөрөнгийн дүн **/4,796,231,269.78-4,847,781,033.89/= (51,549,764.11)** төгрөгөөр **өөрийн хөрөнгийн чадвар буурсан** байна.
4. Тайланд үед өмнөх оноос 687,075,429.99 төгрөг буюу 10 дахин хувиар алдагдал өссөн байна.

Дээрх асуудлыг арилгах зөвлөмж өгч, компанийн үйл ажиллагаа санхүүгийн тайланд **"Хязгаарлалттай санал"** дүгнэлт өгч байна.

Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх Аудиторын үүрэг, хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитын ажлаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй аудитын хамрах цар хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар компаниас ирүүлсэн баримт материалын хүрээнд илэрсэн дутагдал, зөрчлийн талаарх асуудлыг зөвлөмжөөр удирдлагад танилцуулан хүргүүлсэн болно.

Тайлангийн хэрэглээний хязгаарлалт

Энэхүү аудиторын тайланг Компанийн тухай хуулийн 94.1, 95.1 дүгээр зүйлүүдэд заасны дагуу компанийн удирдлага, хувьцаа эзэмшигчдэд зориулан бэлтгэсэн. Бид уг тайлангийн агуулгын хүрээнд аливаа нэг гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК

УБ ХОТ ЧД 2 ДУГААР ХОРОО

Огноо: 2026.05.11

УДИРДЛАГЫН ТӨЛӨӨЛЛИЙН ЗАХИДАЛ

Манай байгууллагын 2025 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид санхүүгийн тайлангаа холбогдох санхүүгийн тайлагналын стандарт болон заавар журмын дагуу бэлтгэсэн талаар саналаа илэрхийлэх зорилгоор энэхүү захидлыг бичиж байна Бид санхүүгийн тайлангаа холбогдох санхүүгийн тайлагналын стандарт болон заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй гэдгээ баталгаажуулж байна.

Энэ захидалд дурдсан зарим зүйлүүд нь материаллаг гэж үзэх боломжгүй байж болох юм . Учир нь бид санхүүгийн тайлангийн хэрэглэгчийн шийдвэрт нөлөө үзүүлэхүйц алдаа эсвэл буруу тайлагналыг материаллаг гэж үзсэн.

Бид 2025 оны 02 сарын 27-ний өдрийн байдлаар өөрсдийн мэдлэг, итгэл үнэмшлийн дагуу дараах зүйлүүдийг баталгаажуулж байна.

- Бид санхүүгийн тайлангуудыг холбогдох санхүүгийн тайлагналын стандарт, заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн,
- Бид санхүүгийн холбогдолтой бүх данс бүртгэл, тоо дүн, бүх шатны удирдлагын хурлын тэмдэглэл болон саяхан болсон боловч хараахан бэлтгэгдээгүй байгаа хурлын тэмдэглэл зэрэг бүх мэдээллээр хангасан,
- Санхүүгийн тайлагналтай холбоотой аливаа хууль бус үйл ажиллагаа явуулсан талаар холбогдох байгууллагаас мэдээлэл ирээгүй,
- Бүртгэл тайланд тусгагдаагүй аливаа материаллаг ажил гүйлгээ байхгүй,
- Удирдлага болон бусад гүйцэтгэх ажилтнуудтай холбоотой залилан эсвэл санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх залилантай холбоотой нөхцөл байдал үүсээгүй,
- Холбоотой талуудын ажил гүйлгээ, бүх гол чухал тооцоолол, удирдлагаас тодруулах ёстой материаллаг шинжтэй бүх зүйлсийг санхүүгийн тайлангийн тодруулгын хэсэгт бүрэн тусгасан,
- Санхүүгийн тайланд тодруулагдах ёстой хууль зөрчсөн үйл ажиллагаа болон шүүхийн томоохон хэмжээний зарга маргаан, ирээдүй үеийн өр төлбөртэй холбоотой асуудал үүсээгүй,
- Байгууллага нь бүх хөрөнгийнхөө хувьд хууль ёсны эзэмшлийн гэрчилгээтэй бөгөөд хөрөнгийг хууль бусаар ашиглах гэх мэт үйл ажиллагаатай холбоотой зүйл гараагүй.
- Санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлөх бүх гэрээ хэлэлцээрүүдийг бид дагаж мөрдсөн.
- Тайлагналын өдрийн дараах аливаа үйл явдал тохиолдоогүй бөгөөд энэхүү захидал бэлтгэсэн өдрийн байдлаар залруулга болон тодруулга шаардлагатай ажил гүйлгээ гараагүй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ / М.Даваасүрэн /

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ / Х.Ариунсанаа /

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

01. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ган хийц ХК (цаашид "компани" гэх) нь 1985 онд барилгын төмөр хийц үйлдвэрлэл чиглэлээр анх үүсгэн байгуулагдсан байна. Регистр 2090988, Улсын бүртгэлийн гэрчилгээ 90100001016 дугаартай 2 гишүүнтэй 24,246.4 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй 140 гишүүнтэй.

Ган хийц ХК нь Монгол Улсын барилгын материалын үйлдвэрлэлийн салбарт орчин үеийн техник, технологийг ашиглан, холбогдох чанар стандартын шаардлага хангасан эцсийн бүтээгдэхүүнийг бэлтгэн, харилцагчиддаа газар дээр нь хурдан шуурхай хүргэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Ган хийц ХК нь жилд 300 тн үйлдвэрлэх хүчин чадалтай, тоног төхөөрөмж бүхий төмөр хийцийн үйлдвэртэй. Ган хийц ХК-ний үйлдвэр, оффис нь Улаанбаатр хот, Сонгинохайрхан дүүрэг, 7-р хороо, Нарангийн гудамж, Ган хийц ХК-ний өөрийн байранд байрладаг.

КЭБАТ-ЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Овог Нэр	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	Д.Оюунзул	Гүйцэтгэх захирал	0 %
2	Х.Ариунсанаа	Нягтлан бодох	0 %

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Овог Нэр	Гишүүнчлэл	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	М.Даваасүрэн	ТУЗ-ийн дарга	71 %
2	Ж.Долгорсүрэн	ТУЗ-ийн гишүүн	0 %
3	Б.Гантулга	ТУЗ-ийн гишүүн	0 %
4	Б.Ганбат	ТУЗ-ийн гишүүн	0 %
5	Б.Эрдэнэбаяр	ТУЗ-ийн гишүүн	0 %
6	П.Төвсанаа	Хараат бус ТУЗ-ийн гишүүн	0 %
7	Ц.Хангай	Хараат бус ТУЗ-ийн гишүүн	0 %
8	Э.Уганцэцэг	ТУЗ-ийн гишүүн	0 %
9	Д.Оюунзул	ТУЗ-ийн гишүүн	0 %

НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

№	Овог Нэр	Эзэмшиж буй хувьцааны хувь	Бусад компанийн хувьцааг эзэмшиж буй байдал	Түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд
1	Маньдар Даваасүрэн	71 %	Байхгүй	Байхгүй
2	Хасвуу ХХК	18 %	Байхгүй	Байхгүй
3	Аргай бэст ХХК	1 %	Байхгүй	Байхгүй

№	Овог Нэр	Эзэмшиж буй хувьцааны хувь	Бусад компанийн хувьцааг эзэмшиж буй байдал	Түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд
4	Бусад	10%	Байхгүй	Байхгүй

Ган хийц ХК -ний 242,464 ширхэг хувьцаанд үнэт цаасны 3 компани, 140 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байна.

Компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээнд гүйцэтгэх удирдлага томилсон тушаалын болон компанийн эцсийн өмчлөгчийн бүртгэлийн шинэчлэл хийгээгүй байна. Үүнтэй уялдан компанийн удирдлага болон хувьцаа эзэмшигчид нар өөрчлөгдсөнтэй холбоотой компанийн дүрмийг шинэчлэн баталгаажуулах шаардлагатай байна.Тус компанийн 2025 оны санхүүгийн үзүүлэлтийг товч харуулбал:

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Нийт хөрөнгө-**4,796,231,269.78**
- Өр төлбөрийн нийт дүн-**4,847,781,033.89**
- Эзэмшигчдийн өмчийн дүн(**51,549,764.11)**
- Нийт гаргасан хувьцаа-**242,464 ширхэг**

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

- Нийт борлуулалтын орлого-**948,345,304.48**
- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг-**738,840,701.04**
- Нийт ашиг/ алдагдал-**209,504,603.44**
- Цэвэр ашиг/алдагдал-**(693,660,071.83)**
- Ногдол ашиг /энгийн/**0**
- Ногдол ашиг /давуу эрхийн/**0**
- Нэгж хувьцааны дансны үнэ-**100**

САНХҮҮГИЙН ХАРЬЦААНУУД

- Нийт хөрөнгийн өгөөж /ROA/- (-0.144%)
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж /ROE/-(-13.4%)
- Нийт хөрөнгийн эргэц /ROTA/-(0.19)
- Нэгж хувьцааны өгөөж /EPS/- (-123.59)

Тус компани алдагдалтай ажилласнаас шалтгаалан санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд хангалтгүй сөрөг гарсан тул эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулах шаардлагатай байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Тус компани нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 361 дугаар “Маягт заавар батлах тухай ” тушаалын Аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” 1 дүгээр, “Санхүүгийн тайлангийн А маягт”-ыг 2 дугаар хавсралтуудыг үндэслэн бэлтгэсэн.

Компанийн хувьцаа эзэмшигчид компанийн өр төлбөрийг барагдуулах хангалттай мөнгөн хөрөнгөтэй байлгахыг хүлээн зөвшөөрдөг учраас компани санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн.

Стандартын баримтлал ба хэрэгжүүлэлт

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар болон Монгол Улсын зохих хууль, тогтоомжийн дагуу бэлтгэсэн.

02. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОНЦЛОХ БОДЛОГУУД

Гадаад валютын хөрвүүлэлт

Санхүүгийн тайланг төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг юм. Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээг тухайн валютаар болон гүйлгээ хийгдэх үеийн Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлэн, төгрөг/валютаар давхар бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд нэрлэсэн үнийг тогтоосон өдрийн ханшаар хөрвүүлэн балансад тусгах шаардлагатай юм.

Холбоотой талууд

Компанийн санхүүгийн тайланд холбоотой талууд оршин байдаг ба түүнтэй холбоотой санхүүгийн болон үйл ажиллагааны бодлогын шийдвэрт оролцдог хувьцаа эзэмшигчийн төлбөр тооцооны асуудлыг тодруулан тайлагнах шаардлага үүссэн байна. Үүнтэй холбогдон зээл төлбөр, тооцоо орлогын талаар тодорхой тайлагнаж байх шаардлагатай.

Зээлийн хүү

Зээлийн хүүг анх бүртгэхдээ нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Дараагийн тайлант хугацаа бүрд анх бүртгэсэн нэрлэсэн үнэ болон зээлийн хүүг төлсөн үеийн үнийн зөрүүгээр хорогдуулж, зээлийн хугацаанд үүссэн олз, гарзыг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хүүгийн аргыг ашиглан, орлого үр дүнгийн тайланд ашиг, алдагдлаар тусгана.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар доорх заалтуудыг мөрдлөг болгон ажиллах.

14.1.Энэ хуулийн 8.1.1-д заасан үндсэн болон туслах үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхлэх, түүнчлэн эд хөрөнгө худалдан авах зорилгоор авсан зээлийн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасаж тооцно.

14.2.Албан татвар төлөгч аж ахуйн нэгжийг хяналтдаа байлгадаг Монгол Улсад байнга оршин суугч хувь хүнээс авсан зээлийн хүүгийн төлбөрийг тухайн албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй бөгөөд энэ зардлыг зээл олгосон тухайн хувь хүний ногдол ашигт тооцож албан татвар ногдуулна.

Санхүүгийн тайлан тодруулга, НББ-ын программ хангамжийн талаар.

Компани нь нягтлан бодох бүртгэлээ НББ-ын Diamond программ ашиглан бүртгэдэг.

1. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө ба банкин дахь харилцах данснуудаас бүрддэг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийг Монголбанкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэх ёстой.

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1	Касс дахь мөнгө	49,526.92	67,722,127.32
2	Банкин дахь мөнгө	26,696,281.21	-
3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	-	-
4	**Нийт дүн**	26,745,808.13	67,722,127.32

Компани нь жижиг мөнгөн сан ашиглан мөнгөн гүйлгээг бэлнээр хийж, хадгалж буй нь эрсдэлийг дагуулж байна.

Бэлэн мөнгөний тооллогын бүртгэл нотломж, үлдэгдлийн баталгаажилт хийгээгүй байдлыг дахин хянуулах.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн доорх заалтуудыг зөрчсөн. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна; 13.6-д Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна; 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд мөрдөн ажиллах.

2. Дансны авлага

№	Үзүүлэлт	Дансны авлага	Найдваргүй авлагын хасагдуулаг	Дансны авлага (цэвэр дүнгээр)
1	Эхний үлдэгдэл	**673,733,716.05**	-	**673,733,716.05**
2	Нэмэгдсэн	138,984,909.71	-	138,984,909.71
3	Хасагдсан	221,637,674.73	-	221,637,674.73
3.1	-Төлөгдсөн	221,637,674.73	-	221,637,674.73
3.2	-Найдваргүй болсон	-	-	-
4	Эцсийн үлдэгдэл	**591,080,951.03**	-	**591,080,951.03**

Авлага нь үүссэн тухайн үеийн нэхэмжлэгдэх дүнгээр бүртгэгдсэн. Авлагын хувьд насжилт, цуглуулагдах магадлалыг үнэлэн нөөцийн сан байгуулдаггүй.

3. Татварын авлага

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1	НӨАТ-ын авлага	37,465,357.23	43,897,632.33
2	НДШ-ийн авлага	-	-
	Нийт дүн	37,465,357.23	43,897,632.33

Татварын авлага дансанд НӨАТ төлөгч харилцагчаас зээлээр худалдан авсан худалдан авсан бараа, ажил үйлчилгээний НӨАТ-ыг хойшлогдсон НӨАТ-ын авлагаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.

4. Бусад богино хугацаат авлага

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1	Холбоотой талаас авах авлагын тайлант хугацаанд хамаарах дүн	1,201,986,486.22	1,164,811,646.44
2	Ажиллагчдаас авах авлага	-	-
3	Ноогдол ашгийн авлага	-	-
4	Хүүний авлага	-	-
5	Богино хугацаат авлагын бичиг	-	-
6	Бусад талуудаас авах авлага	406,653,994.68	393,968,101.28
7	Хүмүүсээс авах авлага	-	-
8	Бэлтгэн нийлүүлэгчдээс авах авлага	-	-
Нийт дүн		**1,608,640,480.90**	**1,558,779,747.72**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн заалтыг хэрэгжүүлж авлагын дансны үлдэгдлийг баталгаажуулан, тооцоо нийлсэн актууд үйлдсэн байна.

5. Бараа материал

Бараа материалыг цэвэр боломжит үнэ цэнэ буюу цэвэр боломжит өртгөөр нь бүртгэдэг. Цэвэр боломжит үнэ цэнэ гэж бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад борлуулахаар тооцсон үнээс түүнийг иж бүрдэл болгохоор тооцсон зардал ба борлуулахад тооцсон зардлыг хассан дүн юм.

№	Үзүүлэлт	Түүхий эд материал	Дуусаагүй үйлдвэрлэл	Бэлэн бүтээгдэхүүн	Хангамжийн материал	Нийт дүн
1	Эхний үлдэгдэл (өртгөөр)	194,509,679.30	134,112,308.35	53,033,336.78	129,538,124.30	511,193,448.73

2	Нэмэгдсэн дүн	459,480,798.99	744,499,896.20	18,966,930.71	177,199,866,57	1,400,147,492.47
3	Хасагдсан дүн	359,421,447.68	720,394,812,36	17,600,873,53	162,892,283,16	1,260,309,416.73
4	**Эцсийн үлдэгдэл (өртгөөр)**	**294,569,030.61**	**158,217,392.19**	**54,399,393.96**	**143,845,707._1**	**651,031,524.47**
5	Үнийн бууралтын гарз (-)	-	-	-	-	-
6	Үнийн бууралтын буцаалт	-	-	-	-	-
7	Дансны цэвэр дүн	294,569,030.61	158,217,392.19	54,399,393.96	143,845,707._1	651,031,524.47
7.1	**Эхний үлдэгдэл**	**194,509,679.30**	**134,112,308.35**	**53,033,336.78**	**129,538,124.30**	**511,193,448.73**
7.2	**Эцсийн үлдэгдэл**	**294,569,030.61**	**158,217,392.19**	**54,399,393.96**	**143,845,707._1**	**651,031,524.47**

Бараа материалын байнгын систем ашигладаг ба дундаж өртгийн аргыг хэрэглэдэг. Бараа материалын хувьд худалдан авалтын оффисийн хангамжийн тооцоог бараа материалын дансаар дамжуулаагүй, шууд зардлаар хүлээн зөвшөөрдөг.

6. Урьдчилж төлсөн зардал, тооцоо

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1	Урьдчилж төлсөн зардал	8,443,784.57	3,561,582.88
2	Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн урьдчилгаа	316,818,669.79	
4	**Нийт дүн**	**325,262,454.36**	3,561,582.88

7. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг түүний өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг ба үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг болон хөрөнгийг ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаарах зардлаас бүрддэг. Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар тооцож, байгуулдаг бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацааг татварын аргаар тооцдог.

Үзүүлэлт	Барилга байгууламж	Машин, тоног	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Нийт дүн
Эхний үлдэгдэл	1,796,669,292.19	396,837,918.7	416,890,305.4	35,226,535.20	12,297,636.36	**2,657,921,687 .97**
Нэмэгдсэн дүн	-	-	-	-	-	-
Өөрөө үйлдвэрлэсэн	-	-	-	-	-	-
Хасагдсан дүн	-	-	-	-	-	-
Худалдсан (-)	-	-	-	-	-	-
Бусад	-	-	-	-	-	-

Эцсийн үлдэгдэл	1,796,669,292 .19	396,837,918.7 7	416,890,305.4 5	35,226,535.20	12,297,636.36	**2,657,921,687 .97**
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ						
Эхний үлдэгдэл	581,281,490. 0	116,925,669.8	269,178,304.0	15,447,663.45	7,135,655.10	**989,968,782.5**
Нэмэгдсэн дүн	58,663,387.65	35,193,811.68	24,122,864.60	2,606,674.05	1,898,934.52	**122,485,672.5**
Байгуулсан элэгдэл	58,663,387.65	35,193,811.68	24,122,864.60	2,606,674.05	1,898,934.52	**122,485,672.5**
Хасагдсан дүн	-	-	-	-	-	-
Данснаас хассан хөрөнгийнэлэгдэл	-	-	-	-	-	-
Эцсийн үлдэгдэл	639,944,877.7	152,119,481.5	293,301,168.6	18,054,337.5	9,034,589.62	**1,112454,455.01**
ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН						
Эхний үлдэгдэл	1,215,387,802.14	279,912,248.79	147,712,001.37	19,778,871.75	5,161,981.26	**1,667,952,905 .46**
Эцсийн үлдэгдэл	1,156,724,414 .49	244,718,437.26	123,589,136.77	17,172,197.70	3,263,046.74	**1,545,467,232 .96**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.",12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;12.2.2.эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед;12.2.3.эд хөрөнгө дутагдсан, эд хөрөнгийг хууль бусаар зарцуулсан байж болзошгүй гэж үзсэн үед;12.2.5.аж ахуйн нэгж, байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай шийдвэр гарсан, дампуурлын хэрэг үүсгэсэн үед;12.2.6.хуульд заасан бусад тохиолдолд; гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллахыг сануулж байна.

8. Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгөнд 2,441,900.0 мян төгрөгийн программ хангамж бүртгэсэн байна.

№	Үзүүлэлт	Программ хангамж	Нийт дүн
1.1	Эхний үлдэгдэл	**2,241,900.00**	**2,241,900.00**
1.2	Нэмэгдсэн дүн	-	-
1.2.1	Өөрөө үйлдвэрлэсэн	-	-
1.3	Хасагдсан дүн	-	-
1.3.1	Худалдсан	-	-
1.4	Эцсийн үлдэгдэл	**2,241,900.00**	**2,241,900.00**
2	**ХУРИМТЛАГДСАН ХОРОГДОЛ**	-	-
2.1	Эхний үлдэгдэл	456,226.80	456,226.80
2.2	Нэмэгдсэн дүн	-	-
2.2.1	Байгуулсан хорогдол	227,814.75	227,814.75
2.3	Хасагдсан	-	-
2.3.1	Данснаас хассан хөрөнгийн хорогдол	-	-

2.4	Эцсийн үлдэгдэл	684,041.55	684,041.55
3	**ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН**	-	-
3.1	Эхний үлдэгдэл	1,785,673.20	1,785,673.20
3.2	Эцсийн үлдэгдэл	**1,557,858.40**	**1,557,858.40**

9. Дансны өглөг

Богино хугацаат өр төлбөр нь тайлант хугацаанд үүссэн бараа, үйлчилгээний худалдан авалт, үйл ажиллагааны зардал, татвар, шимтгэл, цалинтай холбогдох өглөг бөгөөд тэдгээрийг үүссэн тухайн үеийн нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг. Өглөгийн хувьд хөнгөлөлт, хасагдуулга тооцдоггүй. Дансны өглөгийн эхний, эцсийн үлдэгдэл баталгаажсан. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах гэсэн заалтыг хангах, дансны өглөг тайлант онд нэмэгдүүлсэн байна.

Дансны өглөг

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1	Дансны өглөг	3,101,072,460.74	3,148,087,699.42
	Нийт дүн	**3,101,072,460.74**	**3,148,087,699.42**

10. Татварын өр

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1	ААНОАТ өр	68,638,817.77	53,786,261.57
2	НӨАТ -ын өр	881,492,803.12	926,503,412.67
3	ХХОАТ -ын өр	95,470,947.84	137,498,520.26
4	Бусад татварын өр	63,412,551.49	105,372,110.69
	Нийт дүн	**1,109,015,120.22**	**1,223,160,305.19**

Татварын өр төлбөрийг нэмэгдүүлж төсөвт төлөх үүрэг хангалтгүй байна.

11. Богино хугацаат өр төлбөр

№	Үзүүлэлт	2024.12.31	валютаар	2025.12.31	валютаар
1	Дансны өглөг	3,101,072,460.74	-	3,148,087,699.42	-
2	Татварын өр	1,109,015,120.22	-	1,223,160,305.19	-
3	НДШ -ийн өглөг	49,561,230.01	-	160,209,248.83	-
4	Ногдол ашгийн өглөг	122,784,233.99	-	122,784,233.99	-
5	Бусад өр төлбөр	161,369,104.00	-	161,369,104.00	-
6	Цалингийн өглөг		-	32,170,442.46	-

	Нийт дүн	4,543,802,148.96	-	4,847,781,033.89	-

Компани татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн их хэмжээний өртэй, дансны өглөгөө нэмэгдүүлсэн зэрэг нь санхүүгийн үйл ажиллагааг эрсдэлд оруулж улсын болон хувийн хэвшлийн байгууллагаас зарласан тендер, худалдан авах ажиллагаанд оролцох боломжийг хязгаарлаж байна. Үүний улмаас борлуулалтын боломж хумигдаж, зах зээлийн байр суурь сулрах, цаашлаад орлогын эх үүсвэр буурах эрсдэл үүсэж байгаа тул уг асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх шаардлагатай байна.

12. Бусад богино хугацаат өр төлбөр

Бусад богино хугацаат өр төлбөрт туслан гүйцэтгэгч нарт төлөх төлбөрийн үлдэгдэл буюу барилгын хуулийн шаардлагаарх баталгаат хугацааны өглөгийг тусгасан байна. 17 харилцагчийн 161,369,104 төгрөгийн баталгааны өглөг байна.

Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Бусад богино хугацаат өр төлбөр	161,369,104.00	161,369,104.00
Нийт дүн	**161,369,104.00**	**161,369,104.00**

13. Орлого хүлээн зөвшөөрөх

Орлогыг хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Орлогод зөвхөн тухайн бизнесийн үйл ажиллагаанаас хүлээн авсан болоод ирээдүйд хүлээн авах эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал хамаарна. Суутгасан татвар, барааны болон үйлчилгээний хураамж, нэмэгдсэн өртгийн татвар зэрэг гуравдагч талын өмнөөс цуглуулсан дүн нь аж ахуйн нэгжийн эдийн засгийн өгөөжид хамаарахгүй бегөөд эзэмшигчдийн өмчийг нэмэгдүүлэхгүй. Иймээс эдгээрийг орлогын дүнгээс хасаж тооцдог. Компанийн хувьд орлогын хүлээн зөвшөөрөлт дараах байдалтай байна. Үүнд:

- Төсөлт ажлын борлуулалтын орлого /Ажил үйлчилгээ үзүүлсэний орлого/
- Үйлдвэрлэх цехийн борлуулалтын орлого
- Барилгын зургийн борлуулалтын орлого
- Түрээсийн орлого
- Бусад борлуулалтын орлого

Орлогоос нэмэгдсэн өртгийн албан татварыг хассан дүнгээс худалдааны хөнгөлөлт, буцаалт зэргийг хасаж тооцдог боловч тайлант онд борлуулалтын буцаалт хийгдээгүй байна. Тайлант оны 1-12-р сарын НӨАТ-ын тайлангаар тайлагнасан борлуулалтын орлогын өссөн дүнг орлогын албан татварын тайлангаарх тайлагнасан дүн, санхүүгийн тайлангаар тайлагнасан орлогын дүнтэй тулган шалгахад зөрүүгүй буюу тохирч байсан.

14. Борлуулалтын орлого болон борлуулалтын өртөг

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31

1	Борлуулалтын орлого:	**2,119,055,738.19**	948,345,304.48
1.1	Бараа, бүтээгдэхүүн борлуулсны орлого:	**2,119,055,738.19**	948,345,304.48
2	Нийт борлуулалтын орлого	-	-
3	**Борлуулалтын буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралт (-)**	-	-
4	**Цэвэр борлуулалт**	**2,119,055,738.19**	948,345,304.48
5	**Борлуулсан бүтээгдэхүүний өртөг:**	-	-
5.1	Борлуулсан бараа, борлуулалтын өртөг	1,131,739,657.26	738,840,701.04
6	**Нийт борлуулсан бүтээгдэхүүний өртөг**	**1,131,739,657.26**	738,840,701.04

Борлуулалтын орлогыг өмнөх оноос буурсан байна.

15. Хүүний орлого

Үр ашигт хүүгийн аргыг ашиглан хүүгийн орлогыг хүлээн зөвшөөрч аккурэл сууриар бүртгэдэг.

---

16. Бусад зардал

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1	Алданги, торгуулийн зардал	5,614865.02	-
2	Хандивын зардал	1,850,000.00	1,452,000.00
3	Найдваргүй авлагын зардал	37,174,839.78	37,174,839.78
4	Бусад төрөл	-	9,748,828.58
	Нийт дүн	**44,639,704.80**	**48,375,668.36**

17.Ерөнхий удирдлагын зардал

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1	Ажиллагчдын цалингийн зардал	533,756,531.90	492,147,557.88
2	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	61,138,903.08	52,963,715.69
3	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	31,514,835.90	33,147,548.27
4	Томилолтын зардал	332,199.09	-
5	Бичиг хэргийн зардал	2,333,483.46	1,353,306.41
6	Шуудан холбооны зардал	9,203,951.44	6,476,699.25
7	Мэргэжлийн үйлчилгээний зардал	23,950,090.91	12,045,454.55
8	Сургалтын зардал	700,000.00	450,000.00
9	Сонин сэтгүүл захиалгын зардал	-	-
10	Даатгалын зардал	4,404,020.00	-
11	Ашиглалтын зардал	37,358,055.11	45,584,445.16
12	Засварын зардал	54,882,837.33	16,260,702.79
13	Элэгдэл, хорогдлын зардал	109,752,975.76	122,061,891.90

14	Түрээсийн зардал	-	-
15	Харуул хамгааллын зардал	-	-
16	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	1,836,987.66	864,497.00
17	Тээврийн зардал	-	-
18	Шатахууны зардал	11,636,415.85	7,144,531.98
19	Зээлийн хүүгийн зардал	-	-
20	Хөдөлмөр аюулгүй байдлын зардал	5,301,818.19	-
21	Зар сурталчилгааны зардал	2,302,909.09	11,063,358.52
21	бусад зардал	47,122,210.83	53,051,590.73
	Нийт дүн	**944,895,804.60**	**854,615,300.13**

18 Цалингийн зардал

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1	Үйлдвэрлэл, үйлчилгээний	-	-
2	Борлуулалт, маркетингийн	-	-
3	Ерөнхий ба удирдлагын	533,756,531.90	492,147,557.88
4	Бусад төрөл	-	-
	Нийт дүн	533,756,531.90	492,147,557.88

19 Санхүүгийн зардал

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1	Зээлийн хүүгийн зардал	1,535,215.77	-
2	Банк, санхүүгийн үйлчилгээний зардал	619,617.33	173,779.78
3	Бусад төрөл	-	-
	Нийт дүн	**2,154,833.10**	**173,779.78**

20 Орлогын татварын зардал

№	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
1	Тайлант үеийн орлогын татварын зардал	16,368,160.53	-
2	Хойшлогдсон татварын зардал	-	-
	Нийт дүн	**16,368,160.53**	

21 Эздийн өмч

№	Үзүүлэлт	Тоо ширхэг	Дүн (төгрөгөөр)	Тоо ширхэг	Дүн (төгрөгөөр)	(Төгрөгөөр)
1	Эхний үлдэгдэл	242,464	24,246,400.00	242,464	24,246,400.00	-
2	Нэмэгдсэн	-	-	-	-	-
3	Хасагдсан	-	-	-	-	-
4	**Эцсийн үлдэгдэл**	**242,464**	**24,246,400.00**	**242,464**	**24,246,400.00**	-

Тус компанийн эзэмшигчдийн өмч нь өөрийн хөрөнгө (дүрмийн сан), эздийн өмч, өмнөх үеийн болон тайлант хугацааны хуримтлагдсан ашиг, алдагдлаас бүрддэг.
Компани нь 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангаар нийт хөрөнгөөс өр төлбөрийн дүнг хасвал өөрийн хөрөнгийн дүн **/4,796,231,269.78- 4,847,781,033.89/= (51,549,764.11)** төгрөг буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн /24,246,400.00 төгрөг/-гээс **өөрийн хөрөнгийн чадвар буурсан** байна. Тайлант онд ногдол ашиг тараагаагүй.
Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг засан хэрэгжүүлэх ажлын талаар:

1. Өмнөх оны аудитын тайлангийн зөвлөмжийг хэрэгжүүлэх;
2. Компани нь тасралтгүй үйл ажиллагаанд эрсдэл учирч болзошгүй ба тайлант үед алдагдалтай ажилласныг өөрийн хөрөнгийн төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх;
3. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг төсөвт төлөх үүргээ биелүүлж ажиллах;
4. Улсын бүртгэлийн гэрчилгээнд компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлага болон эцсийн өмчлөгчийн шинэчлэл өөрчлөлтийг хийх;
5. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.”,12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ;гэсэн заалтыг хэрэгжүүлж кассын дансны үлдэгдлийг сар бүр тоолж үлдэгдлийг баталгаажуулж хэвших;
6. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах;
7. Дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж, эрсдэлээс сэргийлэхийг анхааруулан зөвлөж байна.

Дундманхайдай аудит ХХК:
Аудитор Ж.Бямбажав

Ган хийц ХК:
Зөвшөөрч Танилцсан: Захирал М.Даваасүрэн

Нягтлан бодогч Х.Ариунсанаа

“ГАН ХИЙЦ“ ХК-ИЙН ТУЗ-ЫН
ДАРГА М.ДАВААСҮРЭН БОЛОН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ НАРТ

УДИРДЛАГАД ХҮРГЭХ ЗАХИДАЛ

1. Санхүүгийн тайлагналын талаар

Бодит байдал:

1. Тайлант онд татвар төлбөр төлөөгүй шалтгаанаар харилцах дансаа хаалгаж, мөнгөн гүйлгээг жижиг мөнгөн сангийн дансаар дамжуулан хийсэн боловч Жижиг мөнгөн сангийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй байна.
2. Бараа материалын зарим худалдан авалтад И баримтыг хавсаргаагүй
3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж батлуулаагүй.

Дээрх зөрчлийг арилгаж ажиллахыг удирдлагын сонорт анхааруулж байна.

Зөвлөмж:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан, мөрдөж ажиллах
2. Тайлант үед касс, банкны харилцах дансны үлдэгдлийг баталгаажуулан, тайлагнаж байх.
3. НББ-ийн анхан шатны баримт,бүртгэл тайланг И баримтаар баталгаажуулж ажиллах
4. Компани нь 2025 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангаар нийт хөрөнгөөс өр төлбөрийн дүнг хасвал өөрийн хөрөнгийн дүн **/4,796,231,269.78-4,847,781,033.89/= (51,549,764.11)** төгрөг буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн /24,246,400.00 төгрөг/-гээс **өөрийн хөрөнгийн чадвар буурсан** байна

2. Дотоод хяналтын талаар

Бодит байдал:

1. Санхүүгийн тайланд тусгасан татварын өглөг 2025 оны 12 дугаар сарын 31-өдрийн байдлаар 1,223,015,160,305.19 буюу өмнөх оны үлдэгдлээс 114,145,184.97 төгрөгөөр , нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг 160,209,248.83 буюу өмнөх оны үлдэгдлээс 110,648,018.82 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг төсөвт төлөх үүргээ биелээгүй байна.
2. Дээрх өр төлбөр болон компаний алдагдалтай байдлыг харгалзан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд сар бүр олгож цалин, урамшууллыг ТУЗ зөвхөн хуралдсан цагт нь олгох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Зөвлөмж:

1. Аудитын зөвлөмжийг биелүүлж ажиллах;

2. Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг төсөвт төлөх үүргээ биелүүлж ажиллах;
3. Жижиг мөнгөн сангийн данс ашигласан тохиолдолд дансны үлдэгдлийг тоолж, баталгаажуулж ажиллах;
4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллах;
5. Улсын бүртгэлийн гэрчилгээнд компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлага болон эцсийн өмчлөгчийн шинэчлэл өөрчлөлтийг хийх;
6. Үндсэн хөрөнгийн тооллогыг биечлэн хийж, үлдэгдлийг баталгаажуулж байх,

3.Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн талаар

Компанийн удирдлага, нягтлан бодогч нар нь дараах эрх, үүргийг баримталж ажиллах Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн боловсруулан, түүний дагуу үнэн зөв тайлагнаж байх,
- Байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээллээр санхүүгийн байдлыг хангах ажлыг зохион байгуулах,
- Холбоотой талын тооцоог хянаж, эрсдэлээс сэргийлэхийг зөвлөж байна.

Дээрх зүйлсийн нөлөөллийг санхүүгийн тайланд тусган ажиллах нь компанийн үүрэг хариуцлага гэдгийг сануулж байна.
Удирдлагын захидлыг монгол хэл дээр 2 эх хувь бэлтгэсэн болно.
Бидний өгч буй зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ гэдэгт итгэж байна. Та бүхний ажилд амжилт хүсье.

Ган хийц ХК:
Зөвшөөрч Танилцсан: Захирал М.Даваасүрэн

Нягтлан бодогч Х.Ариунсанаа

Дүнд найдах
Аудит ХХК аудитор Ж.Балбаатар

ДУНДМАНХААДАЙ АУДИТ ХХК

2026 оны 5-р сарын 11-ны өдөр

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД



Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ХӨРӨНГӨ**		
1.1	**Эргэлтийн хөрөнгө**		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	26,745,808.13	67,722,127.32
1.1.2	Дансны авлага	673,733,716.05	591,080,951.03
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	37,465,357.23	43,897,632.33
1.1.4	Бусад авлага	1,608,640,480.90	1,558,779,747.72
1.1.5	Бараа материал	511,193,448.73	651,031,524.47
1.1.6	Урьдчилж төлсөн зардал тооцоо	325,262,454.36	3,561,582.88
1.1.7	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**3,183,041,265.40**	**2,916,073,565.75**
1.2	**Эргэлтийн бус хөрөнгө**		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,667,952,905.46	1,545,467,232.96
1.2.2	Биет бус хөрөнгө	1,785,673.20	1,557,858.45
1.2.3	Урт хугацаат хөрөнгө оруулалт	333,132,612.62	333,132,612.62
1.2.4	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**2,002,871,191.28**	**1,880,157,704.03**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**5,185,912,456.68**	**4,796,231,269.78**
2	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ**		
2.1	**ӨР ТӨЛБӨР**		
2.1.1	**Богино хугацаат өр төлбөр**		
2.1.1.1	Дансны өглөг	3,101,072,460.74	3,148,087,699.42
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	32,170,442.46
2.1.1.3	Татварын өр	1,109,015,120.22	1,223,160,305.19
2.1.1.4	НДШ-ийн өглөг	49,561,230.01	160,209,248.83
2.1.1.5	Ногдол ашгийн өглөг	122,784,233.99	122,784,233.99
2.1.1.6	Бусад богино хугацаат өр төлбөр	161,369,104.00	161,369,104.00
2.1.1.7	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.8	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**4,543,802,148.96**	**4,847,781,033.89**
2.1.2	**Урт хугацаат өр төлбөр**		
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.6	**Урт хугацаат өр төлбөрийн дүн**	**0.00**	**0.00**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**4,543,802,148.96**	**4,847,781,033.89**
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	0.00	0.00
2.3.2	Хувийн өмч	24,246,400.00	24,246,400.00
2.3.3	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	798,700,593.97	798,700,593.97



2.3.4	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00
2.3.5	Хуримтлагдсан ашиг	-180,836,686.23	-8,496,758.08
2.3.6	**Эздийн өмчийн дүн**	**642,110,207.72**	**-51,549,764.11**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ**	**5,185,912,456.68**	**4,796,231,269.78**

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ТАЙЛАН

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	**Борлуулалтын орлого (цэвэр)**	**2,119,055,738.19**	**851,170,605.36**
2	Борлуулалтын өртөг	1,131,739,657.26	738,840,701.04
3	**Нийт ашиг (алдагдал)**	**987,316,080.93**	**112,329,904.32**
4	Түрээсийн орлого	117,482,147.15	97,174,699.12
5	Хүүгийн орлого	180,889.36	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	984,540,261.71	854,789,079.91
11	Санхүүгийн зардал	1,535,215.77	0.00
12	Бусад зардал	5,614,865.02	0.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-13.12	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	-103,505,243.13	-48,375,595.36
18	**Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)**	**9,783,518.69**	**-693,660,071.83**
19	Орлогын татварын зардал	16,368,160.53	0.00
20	**Татварын дараах ашиг (алдагдал)**	**-6,584,641.84**	**-693,660,071.83**
21	**Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)**	**0.00**	**0.00**
22	**Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)**	**-6,584,641.84**	**-693,660,071.83**
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	**Орлогын нийт дүн**	**-6,584,641.84**	**-693,660,071.83**
25	**Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)**	**0.00**	**0.00**

ГАН ХИЙЦ ХК УЛААНБААТАР ХОТ

ДҮНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК. АУДИТОР-02.

АУДИТ ХИЙСЭН ӨМЧ ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	24,246,400	0	0	798,700,593.97	0	0	-95,234,163.39	727,712,830.58
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0.00	0	0	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	24,246,400	0	0	798,700,593.97	0	0	-95,234,163.39	727,712,830.58
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0.00	0	0	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0	0.00	0	0	0.00	0.00
6	Зарласан ногдол ашиг	0	0	0	0.00	0	0	0.00	0.00
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	0.00	0	0	-6,584,641.84	-6,584,641.84
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0.00	0	0	0.00	0.00
9	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	24,246,400	0	0	798,700,593.97	0	0	-180,836,686.25	642,110,307.72
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0.00	0	0	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	24,246,400	0	0	798,700,593.97	0	0	-180,836,686.25	642,110,307.72
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0.00	0	0	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0	0	0	0.00	0	0	0.00	0.00
14	Зарласан ногдол ашиг	0	0	0	0.00	0	0	0.00	0.00
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	0	0.00	0	0	-693,660,071.83	-693,660,071.83
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0	0	0	0.00	0	0	0.00	0.00
17	2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	24,246,400	0	0	798,700,593.97	0	0	-874,496,758.08	-51,549,764.11

ДУНДМАНХАЙДАЙ АУДИТ ХХК.
АУДИТОР-02.

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант үеийн дүн	Өссөн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,224,464,663.31	1,224,464,663.31
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	1,224,464,663.31	1,224,464,663.31
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,183,488,344.12	1,183,488,344.12
1.2.1	Ажиллагчдад төлсөн	303,075,874.15	303,075,874.15
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,704,800.00	5,704,800.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	863,645,890.19	863,645,890.19
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	0.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	0.00	0.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,888,000.00	10,888,000.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	173,779.78	173,779.78
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	40,976,319.19	40,976,319.19
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсаны орлого	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	40,976,319.19	40,976,319.19
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,745,808.13	26,745,808.13
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	67,722,127.32	67,722,127.32

2090988 115204692
ГАН ХИЙЦ КОМПАНИ
ГАН ХИЙЦ ХК
УЛААНБААТАР

ДУНДМАНХАЙДАН АУДИТ ХХК.
АУДИТОР-02.